



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 06 сарын 24 өдөр

Дугаар А/70

Улаанбаатар хот

“Бумбат алтай ҮЦК” ХХК арилжаанд оролцох эрхийг түдгэлзүүлэх тухай

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10.11 дэх заалт, “Үнэт цаасны арилжаанд оролцох эрх олгох журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалт, Санхүүгийн Зохицуулах Хорооны Улсын байцаагчийн 2022 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 136 тоот албан шаардлагыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн гишүүн “Бумбат алтай ҮЦК” ХХК-ийн арилжаанд оролцох эрхийг 2022 оны 06 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн 2 сар хүртэл хугацаагаар түр түдгэлзүүлсүгэй.
2. Үнэт цаасны арилжааны программд нэвтрэх нэр, нууц үг хаах ажлыг Үйл ажиллагааны газрын Арилжааны алба /Д.Алдармаа/-д, тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт зохицуулалтын газрын Хяналт шинжилгээний алба /Д.Баттулга/-д даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Х.АЛТАЙ

1522020143